



Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа

# БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

# #2

2022 он

IV сар

Сар тутмын хэвлэл

<http://www.mnier.mn>

## Сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх хүний нөөцийг чадавхжуулах сургалтын цогц модуль

Сургалтын хөтөлбөр, сурах бичиг нь тодорхой циклийн давтамжтайгаар, энэ чиглэлийн мэргэшсэн хүний нөөцөд түшиглэн боловсруулж, хэрэгжүүлдэг боловсролын цөм баримт бичиг юм. Манай улсын хувьд ЕБ-ын сургалтын хөтөлбөрийг 10 жилд 1 удаа шинэчлэх "Хөтөлбөрийн Менежмент Цикл"-ийг баталсан бөгөөд энэхүү цикл ёсоор сургалтын хөтөлбөрийн шинэ үзэл баримтлал боловсруулах цаашлаад сургалтын хөтөлбөр,

сурах бичгийг шинэчлэн боловсруулах ажлыг эхлүүлэх шаардлагатай болоод байна. Энэ ажлын хүрээнд 1) сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, бусад баримт бичгийг боловсруулах, 2) сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, 3) сургалтын хөтөлбөрийг үнэлэх, сайжруулах хүний нөөцийг тус тус чадавхжуулах сургалтын багц модулийн агуулга, бүтцийг боловсруулж байна.



Хувийн бодол эргэцүүлэл



Багаар эсвэл хосоор хамтран ажиллах



Үзэл санаагаа солилцох



Нэгдсэн хэлэлцүүлэг хийх

## Байгууллагын онол, арга зүйн семинар эхэллээ



Захиргааны зөвлөлийн 2022 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрээр Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн онол, арга зүйн семинарыг зохион байгуулж байхаар тогтсон.

Энэхүү шийдвэрийн дагуу 2022 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр онол арга зүйн семинар амжилттай

зохион байгуулагдлаа.

Тус семинарт Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал М.Итгэл “Өнгөт математик, цахим сургалт-ын хөтөлбөр” сэдвээр эрдэм шинжилгээний ажилтнуудад илтгэл танилцуулж, санал дэв--шүүлэн, хэлэлцүүлэг өрнүүлэв.

Хэлэлцүүлгийн үеэр “Өнгөт математик, цахим сургалтын хөтөлбөр”-ийн онолын үзэл баримтлал, ач холбогдол, давуу тал болон цаашид сайжруулах, амжилттай хэрэгжүүлэх боломж, арга замуудын талаар БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтнууд санал солилцлоо.

## “ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ-II” төслийн уулзалт боллоо

Швейцарын Хөгжлийн Агентлагын удирдлагуудаас БОАЖЯ, БШУЯ-тай хамтран хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийн үндэсний түшиц байгууллага-Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн болон орон нутгийн хэрэгжүүлэгч байгууллага-Байгаль орчны мэдээлэл сургалтын төвийн төлөөлөлүүдтэй уулзалт хийлээ. Уулзалтаар төслийг 2023 оны 6 сарыг дуустал нэг жил үргэлжлүүлэх стратеги, чиглэлүүдийг ярилцлаа.



## “Өглөөний цай” уулзалт зохион байгуулагдлаа



Захиргааны зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хурлын шийдвэрээр сар бүрийн эхний 7 хоногийн 3 дахь өдөр Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн ажилтнууд уулзаж, судалгааны санал солилцох, нээлттэй яриа өрнүүлэх зорилготой “Өглөөний цай” уулзалтыг зохион байгуулдаг уламжлалтай.

Тус уулзалт 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулагдаж, эрдэм шинжилгээний ажилтнууд судалгааны санал солилцон, чөлөөт ярилцлага өрнүүлэв.

Уулзалтад нийт ажилтнуудын 80 хувь нь оролцлоо.

## Захиргааны зөвлөлийн хурал

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн Захиргааны зөвлөлийн хурал 2022 оны 4 дүгээр сард 4 удаа хуралдаж 10 асуудал хэлэлцэж 6 шийдвэр гаргасан.

## Үндсэн хуулийг судалж буй байдал албан боловсролын хүрээнд



Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс Үндсэн хуулийг судалж буй байдал албан боловсролын хүрээнд сэдэвт уулзалтыг 2022 оны 4

дүгээр сарын 18-ны өдөр зохион байгууллаа.

Уулзалтад БШУЯ, УИХ-ын тамгын газар, Парламентын сургалт, арга зүйн хүрээлэн, Үндсэн хуулийн хүрээлэнгийн төлөөлөл оролцов. Тус уулзалтын үеэр “Үндсэн хууль болон парламентын боловсрол”-ыг албан боловсролын агуулгад туссан байдлын шинжилгээний үр дүнг танилцуулж, цаашид албан боловсролын хүрээнд Үндсэн хууль, парламентын боловсролтой холбоотой агуулгыг хэрэгжүүлэх, боловсронгуй болгох, сайжруулах чиглэлээр хамтран ажиллах талаар санал, шийдэл гаргалаа. Үүнд:

- Албан боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөрийн хүрээнд үндсэн хуулийн болон парламентын боловсролын агуулгын шинжилгээ хийх, нийгмийн ухаан (бага, суурь, бүрэн дунд боловсролын)-ы сургалтын хөтөлбөрийн агуулга буюу суралцахуйн зорилтуудыг илүү тодорхой, хэмжигдэхүйц болгох

- Их, дээд сургуулийн багш нар болон мэргэжлийн байгууллага, хүмүүс хамтран оюутанд зориулсан үндсэн хуулийн хичээлийн хөтөлбөр (syllabus) боловсруулах Багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийн модуль сургалтад үндсэн хуулийн болон парламентын боловсролын агуулгыг тусгах, чадамжийг дэмжих чиглэлээр хамтран ажиллах

- Багш нарыг УИХ, орон нутгийн ИТХ болон Үндсэн хуулийн цэц, Хүний эрхийн үндэсний комисс зэрэг байгууллагын үйл ажиллагаатай танилцуулах, суралцах аялалыг зохион байгуулах

## Стратеги төлөвлөгөө (2018-2022)-ний хэрэгжилтийн шинжилгээ

БСҮХ-ийн захирлын тушаалаар томилсон баг Боловсролын хүрээлэнгийн стратегийн төлөвлөгөө, үйл ажиллагааны гүйцэтгэлийн хэрэгжилт, цаашдын бодлого, төлөвлөлтийг сайжруулахад шаардлагатай дүгнэлт, саналыг гаргах зорилгоор хяналт-шинжилгээ хийх ажлыг эхлээд, нийт 4 удаагийн уулзалт, 1 удаагийн сургалт, хэлэлцүүлэг хийв.

## Стратеги төлөвлөгөө боловсруулах ажил

БСҮХ-ийн захирлын тушаалаар томилсон стратеги төлөвлөгөөг боловсруулах баг БСҮХ-тэй ижил чиг үүрэг бүхий дотоод, гадаадын байгууллага, боловсролын судалгааны олон улсын чиг хандлагын талаар мэдээлэл цуглуулан судалж байна.

## Сургалтын хөтөлбөрт туссан чадварын шинжилгээ



Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд, мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын хөтөлбөрт 21 дүгээр зууны чадвар туссан байдал болон 21 дүгээр зууны чадварын олон улсад түгээмэл хэрэглэж буй загваруудыг шинжлэн судлав. [Ажлын явц дэлгэрэнгүй:](#)

## Хос хэлний судлагдахуун болон хэлийг интеграцчилан суралцахуй аргыг турших гарааны судалгаа



Хос хэлний СХИС аргыг турших гарааны судалгааг Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын 3, 5 дугаар сургуулийн 4, 6 дугаар ангийн сонгосон бүлэг, судлагдахууны хүрээнд хийж байна.

Түүнчлэн туршилтын 2 сургуулийн 4-7 дугаар ангийн зорилтот бүлгүүдэд хичээл заадаг багш, сургалтын менежер, нийт 27 хүнд “Хос хэлний сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, идэвхтэй сургалтын аргуудыг хичээлд хэрэглэх арга зүй” сэдэвт сургалт явуулж, улмаар гуравдугаар улиралд судлах 37 нэгж хичээл, 176 ээлжит хичээлийн хөтөлбөр, хэрэглэгдэхүүнийг боловсруулсан байна.

Судалгааны баг асуулга, ярилцлага, сорилын аргаар мэдээлэл цуглуулсан бөгөөд мэдээллийг нэгтгэх ажлыг эхлүүлээд байна.



## Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулийн сургалтын өнөөгийн нөхцөл байдлын судалгаа /70 дугаар сургуулийн жишээн дээр/

БШУЯ-ны хамтран ажиллах албан бичгийн дагуу тус хүрээлэнгийн баг нийслэлийн 70 дугаар тусгай сургуулийн сургалтын өнөөгийн нөхцөл байдалд шинжилгээ хийлээ. Мөн тусгай сургуулийн сургалтын тогтолцооны олон улсын чиг хандлагыг судалж, судалгааны үр дүнд үндэслэн тусгай сургуулийн сургалтын тогтолцооны талаар саналаа БШУЯ-нд хүргүүлээ.

### Нялх, балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн төсөл

Өмнөх сард тус хүрээлэнгээс зохион байгуулсан хэлэлцүүлгээс хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ, хамрах хүрээ, хөтөлбөрийн тохирц, нийцтэй байдал, нийгэм, соёлын туршлага, оролцогч талтай холбоотой өгсөн саналыг тусган нялх, балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн төслийг сайжруулав.

### Цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулах үйл ажиллагааны судалгаа

Энэхүү судалгааны хүрээнд дөрөвдүгээр сард хяналтын буюу ээлжийн багш ажиллаагүй 12 цэцэрлэгт багшийн ажлын байрны зураглалыг тандах зорилгоор ажиглалт хийж, туршилтын 25 цэцэрлэгээс асуулга авч, ярилцлага хийж, цуглуулсан мэдээллийг шалгах, кодлох, нэгтгэх ажлыг хийж байна.

### Вэбсайт шинэчлэгдэж байна



Өгөгдөл боловсруулалт, цахим судалгаа хөгжүүлэлтийн секторын эрдэм шинжилгээний ажилтнууд “mnier.mn” веб сайтыг шинэчлэх тал дээр хөгжүүлэгч нартай хамтран ажиллаж байна.

### Windows Server 2022 үйлдлийн систем шинээр суулгав

Байгууллагын сервер компьютерт үйлчилгээ хийж, Windows Server 2022 үйлдлийн систем шинээр суулгав.

Энэхүү үйлдэлийн систем нь аюулгүй байдлыг эрс сайжруулсан бөгөөд шифрлэлтийн хувьд хариу өгөх хугацаа багасч, өгөгдөл дамжуулах хурдыг нэмэгдүүлсэн юм.

Бас нэгэн томоохон сайжруулалт бол серверийн техник хангамжийн хязгаарлалтыг хамгийн дээд түвшинд хүртэл нэмэгдүүсэн явдал юм. Сервер 2022 нь 64 физик залгуур дээр ажилладаг 48 терабайт санах ой, 2048 логик цөмийг дэмждэг боллоо.

### “Нээлттэй боловсролын судалгааны нэгдсэн цахим сан” хөгжүүлэх, нэвтрүүлэх

Хэн ч, хаанаас ч хүссэн цагтаа хэрэгтэй бүх мэдээллээ орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүйгээр хүлээн авч өөрийн боломжоороо бүтээлчээр судлах, онлайнаар хамтран мэдлэг бүтээх боломжтой боловсролын нээлттэй тогтолцоо бүрдүүлэх шаардлага өнөөгийн нийгэмд үүсээд байна.

### Сургуульд суурилсан хөтөлбөрийн өөрийн үнэлгээний хэрэгсэл боловсруулах ажил (ТХБ-II)

Тус ажлын хүрээнд үндэсний хэмжээнд хэрэгжсэн төслийн өмнөх шатны үр дүн, зөвлөмжүүд, олон улсын туршлагыг судалж, 5 удаа уулзалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа, ажлын явц концепцын хүрээ гаргах, үнэлгээний хэрэгсэл боловсруулах үе шатандаа явж байна.

### “Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах зайн сургалт” судалгаа

БСҮХ болон Нүүдлийн байгаль хамгаалал ТББ-ын хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд “Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах зайн сургалт” судалгааны ажлын арга зүйн сургалтад эрдэм шинжилгээний ажилтан У.Мягмаржав хамрагдаж, өгсөн удирдамж, чиглэлийн дагуу хамтран ярилцлага хийн мэдээлэл цуглуулсан байна.

## Секторуудын мэдээлэл солилцох уулзалт боллоо

БСҮХ-ийн зөвлөх Р.Бат-Эрдэнэ, Боловсролын бодлого, төлөвлөлтийн судалгааны сектор, Сургалтын хөтөлбөр, үнэлгээ, сурах бичгийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтнууд хийгдэж буй судалгаа болон арга зүйн ажлын талаар санал солилцов. СХҮСБСС “Сургалтын хөтөлбөрт туссан

чадварын шинжилгээ” -ний үр дүнг танилцууллаа. Шинэ бүтэц, зохион байгуулалт хийгдсэнтэй холбогдуулан уулзалтыг цаашид тогтмол зохион байгуулж, сургалтын хөтөлбөрийн бодлогын судалгааны ажилд нягт хамтран ажиллах нь чухал гэдгийг онцоллоо.

## БСҮХ-ийн стратеги төлөвлөгөө боловсруулах баг ажиллаж байна



БСҮХ-ийн захирлын 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А/11 тоот тушаалаар “Стратеги төлөвлөгөө боловсруулах багийн бүрэлдэхүүн”-ийг баталсан. Ажлын хэсгийн ахлагчаар ББТСС-ын эрхлэгч Л. Эрдэнэ, 2018-2022 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх багт секторын эрдэм шинжилгээний ажилтан Ж.Энхтүвшин, 2022-2027 оны стратеги төлөвлөгөө боловсруулах багт Г.Баярмөнх, Г.Халиун нар ажиллаж байна. Ажлын хүрээнд стратеги төлөвлөгөө боловсруулах, стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх олон улсын нийтлэг аргачлал, байгууллагын гадаад, дотоод орчны шинжилгээ хийх аргачлал танилцуулах сургалтад хамрагдав. Ажлын хэсгийн зөвлөхөөр Удирдлагын Академийн Удирдлага, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, дэд профессор Г. Жаргал ажиллаж байна.


## СУИС-ийн багш, судлаачидтай хамтран ажиллаж байна

Монгол Улсын төрөөс “Хүмүүнлэг, оюунлаг, ёс суртахуунтай, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг бэлтгэх” зорилт тавьж, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн “Бүх нийтийн соёлын боловсрол”-ын бодлого боловсруулахад анхаарч байна.

“Бүх нийтийн соёлын

боловсрол” дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хүрээнд Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлийн агуулгыг албан, албан бус боловсролын сурах бичигт тусгасан эсэхийг шинжлэх ажлыг Соёлын яам, СУИС-ийн судлаач-дын баг эхлүүлжээ.

БСҮХ, СУИС-ийн хамтын ажиллагааны хүрээнд ЭША Х.Энхжаргал, Р. Содномцэрэн нар ЕБС-ийн 1-12 дугаар ангийн нийгэм, соёл, урлагийн боловсрол олгох чиглэл-ийн сурах бичигт үнэт зүйлийн сэдэв, агуулга туссан байдлын шинжилгээ хийх ажлын удирдамж, ажлын хуудас боловсруулж, зөвлөх үйлчилгээ үзүүлээ.

**БОЛОВСРОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, МЕНЕЖМЕНТИЙН СУДАЛГААНЫ СЕКТОР**

Тус сектор нь БШУ-ны сайдын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/10 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 2.1.4 дэх тусгаснаар Боловсролын эдийн засаг, санхүүжилтийн үр ашиг, өртөг зардал, дунд хугацааны үр нөлөө, эдийн засаг, санхүүгийн загвар, аргачлалуудтай холбоотой асуудлаар судалгаа хийх, бодлогын чиглэлийг тодорхойлох чиг үүрэгтэйгээр байгуулагдсан.

Боловсролын эдийн засаг, менежментийн судалгааны сектор нь Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн бүтцэд шинээр бий болж байгуулагдсан бөгөөд боловсролын эдийн засаг, менежментийн тулгамдсан асуудлуудаар судалгаа хийх үндсэн зорилготой болно. Энэхүү зорилгоо хэрэгжүүлэхийн тулд оролцогч талууд болон бусад сектор, байгууллага, судлаачидтай нягт хамтын ажиллагааг бий болгохыг зорино. Улсын төсөв болон бусад тодорхой санхүүжилтээр хэрэгжүүлсэн боловсролын бодлого, хөтөлбөрийн үр дүн, үр нөлөөг тодорхой болгох нь тус секторын гол зорилт байна.

Эдгээр чиглэлийг гол болгохдоо оролцогч талуудаа дараах байдлаар тодорхойлж тэдний хүлээлтэд хүрэхийг эрмэлзэж ажиллана.

ОРОЛЦОГЧ ТАЛ		ГОЛ ХҮЛЭЭЛТ
1	Боловсролын бодлого хууль боловсруулагчид, тогтоогчид	Төсвийн санхүүжилтийн үр дүн, төсөл, хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө Бодлогын хэрэгжилтын үзүүлэлтүүд Шинэ бодлого боловсруулахад хэрэглэх үндэслэл тооцоо
2	Боловсролын байгууллагууд, ажилтнууд	Улсын дундаж гүйцэтгэлийн үзүүлэлтүүд Тодорхой асуудлаар хийсэн судалгаа
3	Боловсрол судлаачид	Секторт хийгдэж байгаа бүхий л судалгааны тайлан
4	Боловсролын салбарын донорууд, олон улсын хөгжлийн байгууллагууд	Сонирхож буй асуудлаар хийгдсэн судалгааны үр дүн
5	Суралцагчид, эцэг эх, асран хамгаалагчид, нийгэм	Олон улстай харьцуулсан боловсролын гүйцэтгэл, үр дүнгийн үзүүлэлтүүд
6	Гадаадын судлаачид боловсрол	Олон улстай харьцуулж болох судалгааны үр дүнгүүд

**Онцлох мэдээлэл:**

БШУЯ-ны санхүү, хөрөнгө оруулалтын газрын санхүүгийн хэлтэст “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт”-ийн бодлого, эрх зүйн баримт бичиг болон улсын хэмжээнд хийгдсэн томоохон судалгаанд дүн шинжилгээ хийж дүгнэлт, санал боловсруулж хүргүүлээ.



Боловсролын салбарын “Зардал-үр ашгийн шинжилгээ” хийх аргачлал, шалгуур үзүүлэлт тодорхойлох (Education sector analysis methodological guidelines, volume) болон олон улсын туршлагыг судалж байна.

### Цэцэрлэг, ЕБС-ийн багш нарын дунд “Багшийн хөгжилд ахмад багш нарын оролцоо” сэдэвт ЭШХ амжилттай болж өнгөрлөө



БСҮХ-ээс жил бүр үндэсний хэмжээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг ээлжит Эрдэм шинжилгээний хурал нь “Багшийн хөгжилд ахмад багш нарын оролцоо” сэдвийн дор 55 дахь удаагаа 2 өдөр амжилттай болж өнгөрлөө.

Зохион байгуулалтын дагуу Улаанбаатар хотын 8 дүүрэг, 21 аймгаас багш нар 2-р шатнаас шалгарсан 30 илтгэлээ амжилттай хэлэлцүүлээ.

Орхон аймаг, Баян-Өндөр сумын 7-р сургуулийн багш эхний байранд, Сэлэнгэ аймгийн Мандал сумын 2-р сургууль, Өвөрхангай Бат-Өлзий сумын ЕБС-ийн багш нарын багууд дэд байр, УБ хот, БЗД-ийн “Улаанбаатар” ЕБС, УБ хотын Шинэ-Үе сургууль, Хөвсгөлийн Мөрөн сумын “Титэм” ЕБС-ийн багш нарын багууд 3-р байранд, мөн Дархан-Уул аймгийн “Оюуны Ундраа” ЦС болон Хэнтийн аймгийн 1-р сургуулийн багш нарын багууд тусгай байранд тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсанаас гадна эрдэм судлалын ажлыг нь үнэлэн 1 багшийг Засгийн Газрын шагнал БТА цол тэмдэг, 1 багшийг Жуух бичгээр шагнагдлаа.



**“Багш нарын мэргэжлийн өсөлтөд ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх нь”** сэдэвт эрдэм шинжилгээний хурлын тэргүүн байрны илтгэл.

### “Хүүхдийн хөгжлийн онцлог”-ийн талаар 2 өдрийн сургалт семинар



Секторын ЭША, дэд профессор Ц.Лхагвасүрэн ЭНБ дарга С.Санжаабадамын хамт Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ЕБС-ийн удирдах ажилтан, багш нарт “Хүүхдийн хөгжлийн онцлог”-ийн талаар 2 өдрийн сургалт семинарыг орон нутагт нь амжилттай зохион байгуулав. Сургалт семинарт нийт 43 хүн оролцлоо.

## НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛ VS НАСАН ТУРШДАА СУРАЛЦАХУЙ

Насан туршийн боловсрол, насан туршдаа суралцахуй хэмээх ойлголтын үүсэн бий болох үеийн болон хөгжлийн үедээ агуулж ирсэн утга агуулгыг тодруулах нь цаашид манай улс энэ чиглэлээр баримтлах бодлого, эрх зүйн баримт бичигтээ аль нэр томъёог хэрэглэх талаар нэгдсэн ойлголттой болоход энэхүү судалгаа чухал ач холбогдолтой юм.



### UNESCO AND LIFELONG LEARNING

From the late 1960s, UNESCO played an important role laying the foundations for lifelong education as organising principle of education.

In 1970, Paul Lengrand, a staff of UNESCO, published An Introduction to Lifelong Education

Насан туршийн боловсролын үзэл санааг түүхэн талаас нь дараах байдлаар үечилж болохоор байна.

1. Насан туршийн боловсрол үүсэн бий болсон үе (1960-1972 он)
2. Насан туршийн боловсролын хөгжлийн үе (1973-1995 он)
3. Насан туршдаа суралцагч нийгэм рүү шилжих үе (1996 оноос одоо хүртэл)

Насан туршийн боловсрол хэмээх ойлголт нь боловсрол эзэмших орон зай, насны хязгаартай, боловсролын агуулга, арга зүй нь хаалттай байдаг сургуулийн боловсролын тогтолцоог шүүмжилж, сургуульд очихгүй байсан ч сурч болох боломжгүй байсан, насанд хүрэгчдийн боловсрол олж авах эрх тэгш бус байгаагаас үүдэн гарсан байна.

Насан туршдаа суралцахуй хэмээх ойлголт нь суралцагчийг боловсролын гол субъект гэж үзэх болсонтой холбоотой байна. Насан туршдаа суралцахуйн онолд нэг талаас багшлах нөгөө талаас сурах боловсролын үйл ажиллагаанд суралцагчийг идэвхгүй оршихуй бус харин идэвхтэй оршихуй хэмээн хүлээн зөвшөөрч хүний насан туршдаа олж авах боловсролын үйл ажиллагаанд суралцагчийг эн тэргүүнд тавихыг чухалчилж байна.

ПАРАДИГМ	Сургууль төвт боловсрол	Насан туршийн боловсрол
	Багш төвт боловсрол	Суралцагч төвт боловсрол
	Анги танхимын боловсрол	Практикт суурилсан боловсрол

Боловсрол нь зөвхөн боловсролын салбарын үйл ажиллагаа бус нийгмийн бүх салбарын үйл ажиллагааны нэг хэсэг болон өргөжиж байна. Хэн ч хэзээ ч, хаанаас ч сурах боломж нөхцөл бүрдсэн тохиолдолд суралцагч нь өөртөө тохирсон суралцах арга, хэлбэр, агуулгыг сонгож сурах нь илүү үр дүнтэй байна гэсэн судалгааны үр дүнд үндэслэн насан туршдаа суралцах хэмээх нэр томъёог хэрэглэж эхэлсэн байна.

Иймээс цаашид манайх бодлого, эрх зүйн баримт бичигт насан туршдаа суралцахуй хэмээх нэр томъёог хэрэглэх нь зүйтэй юм.

### Christopher Ball:

**“21 дүгээр зуунд тасралтгүй суралцдаггүй хүнд ажлын байр олдохгүй, насан туршдаа суралцах тогтолцоогүй нийгэм (social structure) оршин тогтнож чадахгүй, суралцагчийг хамгийн эхэнд тавьдаггүй сургууль хаалгаа барих болно”**

(Насан туршийн боловсролын Ерөнхий Ассамблей, Ром хот, 1994 он)